



# ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2020 · 07 сар | Дугаар 20

## ГАРЧИГ

- 2–3 Монгол Улс саарал жагсаалтаас гарах нөхцөлийг бүрдүүллээ
- 4 Зохицуулалтын мэдээ
- 5 Гадаад валютын арилжаа эрхлэгч ББСБ-ууд төрийн мэдээлэл солилцооны “Хур” системд холбогдох боломжтой боллоо
- 6 Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа
- 7 Финтек ба регтек
- 7–8 Судлаачийн индэр
- 9–12 Хувьцааны төвлөрөл болон ашгийн удирдлагын хоорондын хамаарлын шинжилгээ
- 12 Танилцуулга
- 13 Санхүүгийн боловсрол
- 14 Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах
- 15 Компанийн засаглал
- 16–19 Зах зээлийн мэдээ
- 20–21 Олон улсын зах зээлийн мэдээ
- 22–23 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс



## Мөнгөжилгээ

Монгол Улсын санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх их үйлийг түүчээлж буй төр, хувийн хэвшлийн санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулалт, санхүүгийн үйлчилгээний мэргэжлийн компаниуд, нийт иргэддээ Тулгар төрийн 2229, Их Монгол Улс байгуулагдсаны 814, Ардын хувьсгалын 99, Ардчилсан хувьсгалын 30 жилийн ой тохиож буй Үндэсний их баяр наадмын мэндийг өргөн дэвшүүлж, хотлоороо энх тунх сайхан наадахыг ерөөн мэндчилье.

Монгол наадам нь бидний түүх, төрт ёсны уламжлал, соёл, ёс заншлыг бүхэлд нь шингээсэн соёлын их өв билээ. Энэ өв соёлыг тээн үргэлжлүүлж, хойч үедээ залгамжлуулан дэлгэрүүлэгч наадамчин олон түмэн, хүчит бөхчүүд, мэргэн харваачид, уяачид, уралдаанч хүүхдүүд та бүхэн минь сайхан наадаарай.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

## МОНГОЛ УЛС СААРАЛ ЖАГСААЛТААС ГАРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЛЭЭ

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага /ФАТФ/ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандартыг гаргасан бөгөөд улс орнууд тус зөвлөмжүүдийг ханган ажиллах үүрэгтэй. Тухайн стандартын биелэлтийг ФАТФ өөрийн аргачлалын дагуу 2 үзүүлэлтээр үнэлдэг бөгөөд үүнд нэг талаас ФАТФ-ын техникийн 40 зөвлөмж, нөгөө талаас тэдгээрийн үр дүнтэй байдлын шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлт багтана. Монгол Улсын хувьд ФАТФ-ын гишүүн байгууллага болох Ази номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг /АНДМУТБ/-ийн гишүүн бөгөөд гишүүнчлэлээрээ дамжуулан уг стандартыг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг.

2019 оны 10 дугаар сарын 18-ний өдрийн ээлжит хурлаар ФАТФ-аас Монгол Улсыг хяналтын буюу стратегийн дутагдалтай орнуудын /саарал жагсаалт/ жагсаалтад оруулж 4 шууд хэрэгжилтийн хүрээнд 6 үүрэг даалгавар өгсөн ба үүрэг даалгаврыг 100 хувь хэрэгжүүлж, саарал жагсаалтаас гарах боломжийг бүрдүүлсэн. Тухайн 6 даалгавраас Хороонд шууд хэрэгжилт 3-ын хүрээний 2 даалгавар шууд хамаарах тул нэн даруй хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг шуурхай хангаж ажиллалаа. Иймд Хорооны хувьд 2019 оны 10 дугаар сарын 18-наас хойш 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл буюу 6 сарын хугацаанд шуурхай ажиллаж, өгсөн үүрэг даалгаврыг боломжит хамгийн богино хугацаанд бүрэн биелүүлж дууслаа.

## Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

- 📍 Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160
- ☎ +976-51-264444
- ✉ press@frc.mn
- 🌐 www.frc.mn
- 📌 Санхүүгийн зохицуулах хороо
- 📌 @FRC\_of\_Mongolia

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар

Үргэлжлэл 2-р нүүрт >>

## Санхүүгийн зохицуулах хорооны

### АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

### ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

### ҮНЭТ ЗҮЙЛС

**Цогц мөн чанар:** Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

**Хариуцлагатай байх:** Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

**Мэргэжлийн байх:** Өндөр мэдлэг, үр чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

**Бие даасан байх:** Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

**Манлайлал, санаачлагатай байх:** Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

**Багаар ажиллах:** Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

**Бидний үнэт зүйлс юм.**



## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### МОНГОЛ УЛС СААРАЛ ЖАГСААЛТААС ГАРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЛЭЭ

Анхны явцын тайлан, тодруулгыг ФАТФ-ын Олон улсын хяналтын бүлэгт 2019 оны 12 сар, 2020 оны 01 дүгээр сард хүргүүлж, БНХАУ-ын Бээжин хотод явагдсан хамгаалалтын үр дүнд “Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд тохирсон, давтан үйлдэхээс сэргийлсэн шийтгэл ногдуулах” даалгаврыг амжилттай биелүүлж, үнэлгээг ахиулж, гүйцэтгэлийг хангасан. Үүний дараагаар ФАТФ-ын 02 дугаар сард Франц улсын Парис хотноо болсон хуралд үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн эрсдэлийн үнэлгээ, хяналт шалгалтыг банкнаас бусад санхүүгийн салбаруудад хийсэн түвшинд хүргэх даалгаврыг авсан. Уг даалгаврыг биелүүлэхтэй холбоотой Хорооноос шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлж, ФАТФ-ын Хамтарсан бүлэгт 2020 оны 5 дугаар сард тайлан, тодруулгыг хүргүүлж, хороо болон бусад холбогдох байгууллагууд өгсөн даалгаврын биелэлтээ 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдөр цахимаар тайлагнаж, амжилттай хамгааллаа.

Шууд хэрэгжилтийн хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх зорилгоор холбогдох төрийн болон өөрийгөө зохицуулах байгууллагууд дараах ажлуудыг хэрэгжүүлээд байна. Үүнд:

1. Санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн зохицуулагч байгууллагууд байгууллагын эрсдэлийг тодорхойлж, эрсдэлийн түвшинд тохируулж хяналт шалгалтын давтамж, хамрах хүрээг тодорхойлж, хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд тохирсон, давтан үйлдэхээс сэргийлсэн шийтгэл ногдуулсан;
2. Мөнгө угаах үйлдлийг мөрдөн шалгах, яллах ажиллагааг нэмэгдүүлсэн;
3. Хилээр мэдүүлээгүй/худал мэдүүлж нэвтрүүлсэн мөнгөн тэмдэгтийг хураан авах, битүүмжлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэх, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн арга хэмжээ авсан;
4. Хориг арга хэмжээний хэрэгжилтээс

зайлсхийх нөхцөл бүрдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулсан;

5. Санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн үйл олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үүргээ хэрхэн биелүүлж байгааг хянах, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн арга хэмжээ авч ажиллалаа.

2017 онд хэвлэгдэн гарсан Харилцан үнэлгээгээр манай улс Техникийн 40 зөвлөмжийн 5-ыг бүрэн биелүүлсэн, 15-ыг дийлэнхийг нь биелүүлсэн, 15-ыг хэсэгчлэн биелүүлсэн, үлдсэн 5-ийг биелүүлээгүй гэж үнэлсэн. Манай улс хэсэгчлэн биелүүлсэн болон биелүүлээгүй зөвлөмжийн үнэлгээг ахиулах зорилгоор 2019 онд хүсэлт өгч биелэлтийг тайлагнаснаар нийт 16 зөвлөмжийн үнэлгээг 1-2 шатаар ахиулсныг 2019 онд хэвлэгдсэн Харилцан үнэлгээний тайланд тусгасан. Биелээгүй үнэлгээтэй зөвлөмж байхгүй хэдий ч хагас хэрэгжилттэй 5 зөвлөмжийн үнэлгээг дээшлүүлэхтэй холбоотойгоор 2020 онд хүсэлт гаргаж, хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна.

Стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтаас гарах хамгийн сүүлийн шат нь газар дээрх үзлэгт хамрагдах юм. Ингэснээр ФАТФ-ын үнэлгээчид газар дээр ирж, шалгалт хийж ФАТФ-ын гишүүдэд тайлагнаснаар тухайн улс “саарал” жагсаалтаас гарах боломжтой. ФАТФ-аас Монгол Улс үүрэг даалгавруудыг амжилттай биелүүлсэн тухай 2020 оны 6 дугаар сарын 30-нд мэдээлж, Ковид-19 цар тахлын нөхцөл байдалтай уялдуулж, газар дээрх үзлэгийг боломжит ойрын хугацаанд зохион байгуулахыг мэдэгдэв.

Хороонд Зөвлөмж 1 /Эрсдэлийн үнэлгээ/, Зөвлөмж 14 /Мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ/, Зөвлөмж 28 /СББМҮҮ-ийн хяналт шалгалт/ шууд болон

шууд бусаар хамаарах бөгөөд дараах ажлуудыг авч хэрэгжүүлж байна.

Үүнд:

1. Улс орнууд эрсдэлээ үнэлж, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх шаардлагатай гэсэн Зөвлөмж 1-ын хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой өөрийн орны эрсдэлээ тодорхойлох, үндэсний эрсдэлийн үнэлгээ хийх зэрэг арга хэмжээг Хороо бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран авч хэрэгжүүлж байна.

Анх 2016 онд Монгол Улс Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ /ҮЭҮ/-г гүйцэтгэсэн бол 2020 онд хоёрдох удаагийн үндэсний эрсдэлийн үнэлгээг гүйцэтгэж эхлэн зохих ажлуудыг хэрэгжүүлж байна. 2016 онд хийгдсэн эрсдэлийн үнэлгээг АНДМУТБ-ээс 'МУ сэдвийг голчлон хөндсөн ч асуудлыг тал бүрээс нь /аюул занал, үр дагавар, эмзэг сул тал/ задлан шинжилсэн Монгол Улсын эрсдэлийн цогц үнэлгээ болж чадаагүй, хувийн сектор, Засгийн газрын оролцоо дутмаг байсан' гэж дүгнэсэн тул энэ удаагийн үнэлгээ нь илүү өргөн хүрээний асуудлыг хөндсөн, хувийн сектор болон эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллаж байгаагаараа бодит, өндөр түвшний ажил болж чадаж байгаа юм.

Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 90 дүгээр тушаалаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж тайлагнах үүрэг бүхий дэд ажлын хэсгийг 82 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан ба үнэлгээний хүрээнд хийх ажлыг 11 модульд хуваан тус бүрийн ажлын хэсгүүдэд даалгасан.

Хорооны хувьд уг 11 модулаас Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн зохицуулалтын 6 салбарт хийх эрсдэлийн үнэлгээг голчлон

хариуцан ажиллаж байна. Үүнд:

- Модуль 4: Үнэт цаасны салбарын эмзэг байдлын үнэлгээ;
  - Модуль 5: Даатгалын салбарын эмзэг байдлын үнэлгээ;
  - Модуль 6.1: Банк бус санхүүгийн салбарын эмзэг байдлын үнэлгээ;
  - Модуль 6.2: Хадгаламж зээлийн хоршоодын эмзэг байдлын үнэлгээ;
  - Модуль 7: Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн салбарын эмзэг байдлын үнэлгээ;
  - Модуль 9: Санхүүгийн хүртээмжтэй бүтээгдэхүүний эрсдэлийн үнэлгээ.
2. Мөнгө, үнэ бүхий зүйл шилжүүлэх үйлчилгээ үзүүлж буй хувь хүн болон хуулийн этгээдийг тусгай зөвшөөрөл эсвэл бүртгэлд хамруулж ФАТФ-ын Зөвлөмжийн холбогдох заалтыг биелүүлж байгаа эсэхэд хяналт шалгалтын арга хэмжээ авбал зохино гэсэн Зөвлөмж 14-ын хүрээнд дараах ажлуудыг хийгээд байна. Үүнд:
- Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн жагсаалтад тогтмол шинэчлэлт хийдэг болсон;
  - Хууль бусаар гадаад валют, мөнгө шилжүүлэх үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн үйлдлийн талаарх мэдээллийг хүлээн авах, тэдгээрт арга хэмжээ авах, олон нийтэд мэдээлэх зорилгоор заавар баталж, хэрэгжүүлж ажиллаж байна;
  - Хороо, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд, хууль сахиулах байгууллага болон бусад хяналт бүхий байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох орчинг бүрдүүлэх гурвалсан гэрээг байгуулсан;
  - Зөвшөөрөлгүй аж ахуйн нэгжид хяналт тавих мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй

тэмцэх алба байгуулсан;

- Тусгай зөвшөөрөлгүй цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын гүйлгээ эрхэлж буй хувь хүн, хуулийн этгээдэд холбогдох арга хэмжээ авсан;
  - Хорооны зөвшөөрөлгүй ББСБ-ын цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэгчдийг илрүүлэх зорилгоор Хорооны орон нутгийн төлөөлөгчидтэй мэдээлэл солилцох чиглэлээр идэвхтэй хамтран ажиллаж байна.
3. Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид /СББМҮҮ/ зохицуулалт, хяналт шалгалтын арга хэмжээнд хамрагддаг байх гэсэн Зөвлөмж 28-ын хүрээнд дараах ажлуудыг хийгээд байна. Үүнд:
- Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага болон үнэт металл, үнэт чулуу, эсвэл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийг хариуцсан шинэ алба нээсэн;
  - 'Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам'-ыг Хорооноос 2020 оны 179 дүгээр тогтоолоор баталсан;
  - Тайлагнах салбаруудын тоог өргөжүүлж, Хорооны зохицуулалттай этгээдүүдэд холбогдох арга хэмжээг авсан;
  - Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын аргачлалыг зохицуулалтын салбаруудад нэвтрүүлэн ажиллаж байна.



## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### ХОРООНЫ ЭЭЛЖИТ ХУРАЛДААН БОЛОВ

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны ээлжит 13 дугаар хуралдаан 2020 оны 7 дугаар сарын 08-ны өдөр хуралдаж, Хорооны зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгчдийн бүртгэл, тусгай зөвшөөрлийн 25 асуудлыг шийдвэрлэсний зэрэгцээ, “Банк бус санхүүгийн байгууллагын гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцлээ.

Санхүүгийн зохицуулах хорооны өмнөх хурлаар батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам”-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Хорооны хуралдаанд танилцуулж журмыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын талаар чиглэлийг гаргалаа.

Хуралдаанаар банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нэг байгууллагад, “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын дагуу хууль, тогтоомжийн нөхцөл, шаардлага хангасан 8 хуулийн этгээдэд үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олголоо.

Мөн эдгээрээс гадна үнэт цаасны брокер, дилерийн үйл ажиллагаа эрхэлдэг 2, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг 2 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг сэргээж, нэр бүхий 5 банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, нэр бүхий 4 хадгаламж, зээлийн хоршооны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, нэр бүхий үнэт цаасны компанийн дилер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх шийдвэрийг тус тус гаргалаа.

### МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР СУРГАГЧ БАГШ НАР БЭЛТГЭВ

Зохицуулалтын салбарын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэгдсэн, мэдээлэх үүрэгтэй этгээдийг чадавхжуулахууц ур чадвар, мэдлэгтэй “Сургагч багш” бэлтгэх зорилгоор 2020 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс 26-ны өдрийн хооронд сертификаттай сургалтыг Банк санхүүгийн академитай хамтран зохион байгууллаа.

Санхүүгийн зохицуулах хороо нь дэлхий дахинд үүссэн нөхцөл байдал, цар тахал ковид-19 вирусээс шалтгаалж танхимын сургалт зохион байгуулах боломжгүй болсон энэ үед Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээрх “Сургагч багш” бэлтгэх 60 цагийн сургалтыг анх удаа орчин үеийн технологид суурилан виртуал хэлбэртэйгээр амжилттай зохион байгууллаа.

“Сургагч багш” бэлтгэх сургалтад Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай 6 салбарт хамааралтай Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо, Монголын даатгалын холбоо, Монголын даатгалын зуучлагчдын холбоо, Монголын банк бус санхүүгийн байгууллагын холбоо, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо, Монголын үл хөдлөх хөрөнгө зуучлагчдын нэгдсэн холбоо, Үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн гүүр нэгдсэн холбоо, Монголын бичил уурхай эрхлэгчдийн дээвэр холбоо, Монголын уран дарханы түмэн эрдэнэс холбоо, Алт арилжаалагчдын холбооны төлөөлөл 50 гаруй тусгай зөвшөөрөлтэй байгууллагын удирдлага, удирдах түвшний албан

хаагчид оролцон амжилттай төгссөн байна.

Сургагч багш нарын зүгээс сургалтын зохион байгуулсан хэлбэрт сэтгэл хангалуун, шинэлэг үр дүнтэй байсныг дурдаад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх чиглэлээр төдийгүй сургагч багшийг ур чадвар, сэтгэл зүй зэрэг олон талт мэдлэгийг олж авсан талаар санал сэтгэгдлээ илэрхийлсэн байна.

### ХУРДАН МОРИНЫ УНААЧ ХҮҮХДИЙН ДААТГАЛЫН ТАЛААР ИРГЭД ДААТГУУЛАГЧДАД АНХААРУУЛАХ НЬ



Даатгалын компани нь бүтээгдэхүүн үйлчилгээгээ гаргахдаа тухай бүр Хорооноос зөвшөөрөл авч ажилладаг бөгөөд одоогоор 10 даатгалын компани “Хурдан морь унаач хүүхдийн даатгал”-ын бүтээгдэхүүн үйлчилгээг Хороонд бүртгүүлсэн байна.

Аливаа баяр наадмын үеэр унаач хүүхдүүд хурдан морины уралдаан, сунгаанд оролцож, улмаар мориноос унаж гэмтэх, моринд дайруулах, өшиглүүлэх гэх мэт осол аваар нэмэгддэг. Иймд тэдгээр хүүхдүүдэд учрах эрүүл мэндийн гэмтэл ослын хохирлыг даатгалаар нөхөн төлөх зайлшгүй хэрэгцээ шаардлагатай байдаг учраас хурдан морины унаач хүүхдийг гэнэтийн ослын даатгалд хамруулах асуудлыг хуульчилсан байдаг.

Гэтэл зарим олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэр бүхий байгууллагаас “Энэ жилийн хувьд уралдаанч хүүхдийн гэнэтийн ослын даатгалд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Үүнд суурь хураамж нь 100 мянган төгрөг, нөхөн олговрын хэмжээ нь 20 сая төгрөг байна. Тухайн даатгал нь дан ганц уралдааны явцад бус бүтэн жил үйлчилнэ.”, “дөрвөн даатгалын компани манай шаардлагыг хангаж байгаа.” гэх мэт худал мэдээллийг олон нийтэд хүргэж байна.

Даатгалын хураамжийн хэмжээг албан журмын даатгалын хувьд хуулиар, сайн дурын даатгалын хувьд даатгалын компанийн тусгай мэргэжилтэн болох актуарч тооцоолсны үндсэн дээр Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлдэг бөгөөд бусад аль нэг байгууллагаас тогтоох эрхгүй болно.

Мөн даатгалын үнэлгээний хэмжээг Иргэний хуулийн дагуу даатгагч, даатгуулагч харилцан тохиролцож тогтоохоор хуульчилсан байдаг. Түүнчлэн Хорооноос бусад аливаа байгууллага нь даатгалын байгууллагад тусгайлан шаардлага тавих эрхгүй болохыг үүгээр мэдэгдэж, иргэд даатгуулагч та бүхэн алдаатай, хуульд нийцээгүй мэдээлэлд төөрөгдөхгүй байхыг хүсье.

## БАЙР СУУРЬ

## ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ ББСБ-УУД ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ “ХУР” СИСТЕМД ХОЛБОГДОХ БОЛОМЖТОЙ БОЛЛОО



Санхүүгийн зохицуулах хорооны Банк бус санхүүгийн байгууллагын газрын референт **Н.Баярсайхан**

**Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулсан журам баталсан гэсэн. Энэ журмын онцлог юу вэ?**

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар “Банк бус санхүүгийн байгууллагын гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам” батлагдсан. Энэхүү журмын гол онцлог нь гадаад валютын арилжаа эрхэлж буй ББСБ нь төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд холбогдож, мөн харилцагчдад и-баримт олгох, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хөнгөвчлөх нөхцөл бүрдсэн. Өөрөөр хэлбэл валют солиулахаар ирсэн харилцагч иргэний үнэмлэх байхгүй тохиолдолд хурууг уншуулан харилцагчийг таних боломжтой болно. Журмын гол зорилго нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Валютын зохицуулалтын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль зэрэг төрөөс баримталж буй урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангуулахад дэмжлэг үзүүлэх юм.

**ББСБ-ууд и-баримтын системд хэрхэн холбогдох вэ?**

Санхүүгийн зохицуулах хороо нь Сангийн яамны харьяа Гааль татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран и-баримт цахим системээр дамжуулан төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд ББСБ-уудыг холбохын тулд эрх зүйн орчинтой уялдуулан дэд бүтцийг шинэчлэх ажлыг зохион байгуулж байна. Тухайлбал, invoice.ebarimt.mn сайтад ББСБ нь татвар төлөгчийн хэрэглэгчийн нэр,

нууц кодоор нэвтрэн валют арилжаа хийх тухай бүрт иргэн, хуулийн этгээдийн цахим и-баримт систем болон и-мэйл хаягт баримтыг илгээх боломжийг бүрдүүлнэ.

**Таны ярьснаар ББСБ нь харилцагчид и-баримт олгохоор болж байгаа юм байна. Тэгэхээр харилцагч валют арилжаа хийсэн баримтаасаа НӨАТ-ын 2 хувийн буцаан олголт авна гэсэн үг үү?**

Монгол Улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.5-д заасан үйлчилгээг дагнан эрхэлж буй хуулийн этгээд нь албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлэхгүй байхаар заасан ба үүнд нь валют солих үйлчилгээ орж байгаа. Иймд иргэдэд өгч буй баримтаар 2 хувийн буцаан олголт өгөхгүй, зөвхөн сугалаанд оролцох боломжтой юм.

**Энэ зохицуулалтын хүрээнд ББСБ-уудад ямар шаардлага тавигдаж байгаа вэ?**

ББСБ-уудын хувьд тухайн и-баримт системд нэвтрэхийн тулд интернетийн орчинд ажиллах, мөн төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг ашиглахтай холбогдуулан хуруу уншигч төхөөрөмжийг худалдан авах шаардлагатай. Тэгэхээр ББСБ-уудын хувьд тодорхой хэмжээний зардал гарна.

**ББСБ-ын салбарт ямар ач холбогдолтой вэ?**

ББСБ-уудыг чадавхжуулах, гадаад валютын арилжааны мэдээг сайжруулах, далд эдийн засгийг ил болгох, ББСБ-уудыг санамсаргүй байдлаар мөнгө угаах гэмт хэрэгт ашиглагдах эрсдэлээс хамгаалах, арилжааны мэдээг хэдэн жилийн дараа ч шүүж харахад хялбархан болж байгаа юм. Ингэснээр тус салбарыг урт хугацаанд тогтвортой, дата мэдээлэл сайтай салбар болж хөгжих, эрүүл оршин тогтноход чухал ач холбогдолтой. Ямар ч салбарт дата мэдээлэл нь бодит нөхцөл байдлаа мэдэрч, ирээдүйн бодлого боловсруулахад маш чухал суурь үзүүлэлт болдог. Тиймээс энэ журмыг хэрэгжүүлснээр ББСБ-ын салбарын харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг илүү хялбарчилж, валют арилжааны гүйлгээний мэдээллийг цэгцтэй хөтөлж, холбогдох төрийн байгууллагуудад мэдээлэх үйл ажиллагааг илүү сайжруулна гэж харж байгаа. Цаашлаад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд ч чухал нөлөөтэй бөгөөд энэ нь салбарын нэр хүндэд сайнаар нөлөөлөх юм.

ББСБ-ууд тус салбарт зөвшөөрөлгүйгээр гадаад валютын арилжаа эрхэлж буй этгээдүүдийг Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлж, хуулийн дагуу холбогдох арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх боломжтой. Мөн Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг ашигласнаар ББСБ нь төрийн мэдээлэлээс харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хөнгөвчилж, үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, нөгөө талаас харилцагчийн мэдээллийг үнэн зөв нийлүүлэх боломж бүрдэнэ.

**Сүүлийн үеийн мэдээ, мэдээлэл өгч ярилцсанд баярлалаа. Таны ажилд амжилт хүсье.**

## ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

### ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хадгаламж, зээлийн хоршоо нь мөнгөн хадгаламж, зээлийн үйл ажиллагааг эрхлэх бөгөөд Хорооноос зөвшөөрсөн, хууль тогтоомжоор хориглоогүй санхүүгийн бусад ажил, үйлчилгээг эрхэлж болдог.

Уг үйл ажиллагааг Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, хуульд нийцүүлэн баталсан дүрэм, журам, нөхцөл шаардлагын үндсэн дээр эрхлэнэ.

Хороо нь өргөдөл, түүний бүрдэл баримт бичиг, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан, тухайн хадгаламж, зээлийн хоршооны тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хороо, тэдгээрийн гишүүд, гүйцэтгэх захирал, ажилтан нь хуульд заасан шаардлагыг хангасан, үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө нь бодитой, үйл ажиллагаанаас учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах арга хэмжээг тусгасан, Хорооноос тогтоосон, хуульд заасан үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлагыг хангасан нотлох бусад баримт бичгийг үндэслэн тусгай зөвшөөрөл олгодог болно.

Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл авахад дараах баримт бичгүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

- Хорооноос баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл;
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
- Үүсгэн байгуулах хурлаас гаргасан үүсгэн байгуулах тухай шийдвэр;
- Үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан үүсгэн байгуулах тухай гэрээ;
- Үүсгэн байгуулагчдын талаарх мэдээлэл;
- Хадгаламж, зээлийн хоршооны дүрэм;
- Хадгаламж, зээлийн хоршооны өөрийн хөрөнгийн хэмжээ;
- Үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө;
- Хадгаламжийн үйл ажиллагааны журам;
- Зээлийн хороо болон зээлийн үйл ажиллагааны журам;
- Эхлэлтийн баланс;
- Тэргүүлэгчид, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал,

нягтлан бодогчийн мэргэжил, мэргэшил, ур чадварын талаарх мэдээлэл;

- Үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах арга хэмжээний талаарх мэдээлэл.

Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)–г татан буулгахтай холбогдсон нарийвчилсан харилцааг Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулиар, тухайн харилцааг нарийвчлан зохицуулаагүй тохиолдолд Иргэний хууль, Хоршооны тухай хууль болон бусад хуульд заасан хэм хэмжээг үндэслэл болгон зохицуулдаг.

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд зааснаар ХЗХ–г (1) шүүхийн шийдвэрээр, (2) Бүх гишүүдийн хурлын шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо (Хороо)–оос бичгээр зөвшөөрсөн тохиолдолд татан буулгана.

1. *Бүх гишүүдийн хурлын шийдвэрээр татан буулгахад дараах зөвшөөрөл болон процессын шаардлагыг хангасан байна:*

- Хадгаламж, зээлийн хоршоог татан буулгах тухай асуудлыг санал хураалтад оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- Хадгаламж, зээлийн хоршоог татан буулгах зөвшөөрөл авахаар холбогдох баримт бичгийг Хороонд ирүүлснээс хойш 30 хоногийн дотор татан буулгах зөвшөөрөл олгох эсэх асуудлыг Хороо хянан шийдвэрлэх бөгөөд шийдвэрийг тухайн хадгаламж, зээлийн хоршоонд хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ.
- Хадгаламж, зээлийн хоршоог татан буулгах тухай бүх гишүүдийн хурлын шийдвэр нь хууль тогтоомж зөрчсөн, эсхүл тухайн хадгаламж, зээлийн хоршооны гишүүд, авлагатай иргэн, хуулийн этгээдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр бол Хороо зөвшөөрөл өгөхөөс татгалзаж болно.

2. *Хороо хадгаламж, зээлийн хоршоог татан буулгах тухай нэхэмжлэлийг дараах тохиолдолд шүүхэд гаргана:*

- Хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон ба хадгаламж, зээлийн хоршоо өөрийн санаачилгаар татан буугдаагүй.
- Хадгаламж, зээлийн хоршоог хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш ажлын 30 өдөрт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тусгай зөвшөөрөл хүсэх тухай өргөдөл гаргаагүй, эсхүл уг хугацаанд тухайн хадгаламж, зээлийн хоршооны эрх бүхий этгээд хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргаагүй нь тухайн хадгаламж, зээлийн хоршоог шүүх татан буулгах үндэслэл болно.
- Хорооноос тусгай зөвшөөрөл олгосноос хойш нэг жилийн хугацаанд тусгай зөвшөөрлөөр олгогдсон үйл ажиллагааг эрхлээгүй, эсхүл эрхэлсэн боловч үйл ажиллагаа нь нэг жилийн хугацаанд тасалдсан хадгаламж, зээлийн хоршооны тусгай зөвшөөрлийг Хороо хүчингүй болгож болно. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсноос хойш гурван сарын дотор тусгай зөвшөөрөл авахаар Хороонд дахин хандаагүй, эсхүл хандсан боловч Хороо тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол уг хадгаламж, зээлийн хоршоог Хорооны хүсэлтээр шүүх татан буулгаж болно.

Мөн Хорооноос тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэрт ажлын 15 хоногийн дотор гомдол гаргаагүй, гомдол гаргах хугацаа өнгөрсөн, эсхүл уг гомдлыг шийдвэр хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор дахин тусгай зөвшөөрөл хүсэх тухай өргөдөл гаргаагүй бол Хороо нь тухайн хадгаламж, зээлийн хоршоог татан буулгах, эсхүл хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах тухай мэдэгдлийг тухайн хадгаламж, зээлийн хоршоонд, мэдээллийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

## ФИНТЕК БА РЕГТЕК

### ROBO-ADVISOR

WealthTech буюу хөрөнгө оруулалтын технологийн нэг буюу робот зөвлөх (Robo-advisor) нь санхүүгийн шийдвэр гаргалтыг хүний оролцоо, хяналт бага эсвэл огт шаардахгүйгээр автоматжуулан тодорхой үе шат, алгоритмуудын дагуу хийдэг дижитал платформ (талбар) юм. Робот зөвлөх нь ерөнхийдөө онлайн харилцагчийн санхүүгийн байдал, хүрэх зорилго зэрэг хувийн мэдээллийг хүлээн авч ашиглан хөрөнгө оруулалтын талаар зөвлөх, эсвэл бүр цаашлаад хөрөнгө оруулалтыг ч хийдэг.

Их хямралын үед буюу 2008 онд Betterment нэртэйгээр анхны робот зөвлөх гарсан ба 2010 оноос эхлэн харилцагчдын мөнгөөр хөрөнгө оруулалтыг хийх үйл ажиллагааг явуулж эхэлсэн байна. Betterment-ийн анхны зорилго нь энгийн онлайн интерфэйсээр дамжуулан харилцагчдын хөрөнгийг удирдаж анхны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх байсан. 2000 оны эхэн үеэс хөрөнгө оруулалтын менежерүүд багцын хөрөнгө оруулалтыг автоматжуулсан

програмыг ашиглаж эхэлсэн учир энэхүү програм нь шинэ зүйл биш байсан ч хэрэглэгчид заавал санхүүгийн зөвлөхөд хандалгүйгээр мэргэжлийн хөрөнгө оруулалтын шийдвэрүүдийг гаргах боломжийг олгосноороо робот зөвлөх нь шинэлэг юм.

Тус салбар нь жил ирэх тусам улам хөгжиж байгаа ба анх гарснаасаа 10 жилийн дараа л гэхэд тэтгэврийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын сонголт, татварын дарамтыг багасгах зэрэг нарийн төвөгтэй шийдвэрүүдийг гаргах боломжтой болсон байна. 2015 онд л гэхэд робот зөвлөхөөр удирдуулсан хөрөнгийн хэмжээ 60 тэрбум ам.долларт хүрсэн ба 2020 онд 2 их наяд ам.доллар, 2025 онд 7 их наяд ам.доллар хүрнэ гэсэн тооцооллыг гаргасан байна.

Ихэнх робот зөвлөхүүдийн хувьд “Орчин үеийн багцын онол”-ыг ашигладаг. Хөрөнгө оруулалтын багцыг бүрдүүлсний дараагаар зах зээл хөдөлгөөнд орсон ч гэсэн багц дахь хөрөнгө оруулалтыг хамгийн оновчтой байхаар хувийн жинг тохируулсаар байдаг.

#### Орчин үеийн багц (портфел)-ын онол

Орчин үеийн багцын онол нь хөрөнгө оруулалтын багц дахь нэг хөрөнгө оруулалтын эрсдэл болон өгөөжийг зөвхөн авч үзэхгүйгээр, тус хөрөнгө оруулалт нийт багцын эрсдэл болон өгөөжид хэрхэн нөлөө үзүүлэхийг тооцдог. Ингэснээр хөрөнгө оруулагч хэд хэдэн хөрөнгө оруулалтыг хийхдээ хүлээгдэж буй эрсдэлийн түвшинд өгөөжийг хамгийн их байлгах, эсвэл хүлээгдэж буй өгөөжийн түвшинд эрсдэлийг хамгийн бага байлгах боломж бүрддэг.

Багцын 30 хувийг хөгжиж буй компаниудын хувьцаанаас, 30 хувийг зах зээлд “хөлөө олсон” компаниудын хувьцаанаас, үлдсэн 40 хувийг Засгийн газрын бондоос зэрэг байдлаар хөрөнгө, үнэт цаас бүр ямар нэгэн байдлаар жинлэгдсэн байдаг. Эдгээр хязгаар нь тодорхой заагийн хүрээнд хэлбэлзэж болох ба хэрэв тогтоосон хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд анхны зорилгод тохируулан хөрөнгө оруулалтын жинг шинээр тооцох зэргээр багцыг байнга тохируулж байдаг.


#### Робот зөвлөхийн давуу тал:

Робот зөвлөхийн гол давуу тал нь санхүүгийн уламжлалт зөвлөх (хүн)-үүдийг бодвол зардал багатай. Ихэнх робот зөвлөх жилд харилцагчийн хөрөнгийн 0.2–0.5 хувьтай тэнцэх хэмжээний шимтгэлийг авдаг нь санхүүгийн зөвлөх мэргэжилтний төлбөрийг (1–2 хувь) бодвол харьцангуй бага байдаг.

Өөр нэгэн давуу тал нь байнга ашиглах боломжтой байнга ашиглагддаг буюу интернеттэй нөхцөлд 7 хоног 24 цагаар холбогдох боломжтой. Ихэнх робот зөвлөхийн удирдах хамгийн бага хөрөнгийн хэмжээ нь 5 мянган ам.доллараас эхэлдэг (зарим нь доод хэмжээ заагаагүй байдаг) бол санхүүгийн зөвлөхүүдийн хувьд хамгийн багадаа 100 мянган ам.доллараар хөрөнгө оруулах боломжтой тохиолдолд үйлчилгээ үзүүлэх нь цөөнгүй байдаг.

Хөрөнгө оруулалтын технологийн компаниудын хамгийн их хэсгийг робот зөвлөхийн төрөл бүрдүүлдэг ба нийт санхүүжилтийн 30 орчим хувийг робот зөвлөхийн компаниудад олгосон байдаг. 2017 оны байдлаар гэхэд АНУ-аас гадна 17 улсад робот зөвлөхийн үйлчилгээг нэвтрүүлсэн ба дараах зурагт робот зөвлөхийн үйлчилгээгээр тэргүүлэх орнуудыг үзүүлээ.

Зураг 1. Робот зөвлөхөөр тэргүүлэх орнууд




Эх сурвалж: CB Insights

2012 оноос хойш робот зөвлөхийн компаниудад олгосон нийт санхүүжилтийн 57 хувийг зөвхөн АНУ-ын компаниуд бүрдүүлж байгаа ба дараагаар нь Герман улс 9 хувь, Англи улс 8 хувийн үзүүлэлттэй байна.


Мөн олон улсын хөрөнгө оруулалтын банк болох “Drake star partners”-ийн 2019 онд гаргасан “The Rise of WealthTech” судалгаагаар робот зөвлөхийн компаниудын хөрөнгө оруулалт 2020 онд 2.2 – 3.7 тэрбум ам.доллар хүртэл байхаар тооцоолсон байна.

Зураг 2. Робот зөвлөхийн компаниудын нийт санхүүжилтэд эзлэх хувь, улсаар



Эх сурвалж: CB Insights

Зураг 3. Робот зөвлөхийн компаниудад оруулах хөрөнгө оруулалтын тооцоолол



Эх сурвалж: Drake star partners

## СУДЛААЧИЙН ИНДЭР

### ХУВЬЦААНЫ ТӨВЛӨРӨЛ БОЛОН АШГИЙН УДИРДЛАГЫН ХООРОНДЫН ХАМААРЛЫН ШИНЖИЛГЭЭ

Мандах их сургууль  
НББ–Статистик 3–р курс  
Оюутан: Батсүх Алтанзул

Удирдсан багш: Доктор, ММНБ, А.Наранцэцэг

#### Хураангуй

Энэхүү судалгааны зорилго нь 2013–2018 онд бүртгэлтэй компаниудын өмчийн хэлбэр ба орлогын менежментийн хоорондын хамаарлыг судлах явдал юм. Чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжих хүртлээ Монголын ихэнх аж ахуйн нэгжүүд төрийн өмчит хэлбэртэй байсан. Төрийн өмчит компаниудыг хувьчлах замаар хөрөнгийн бирж байгуулсан. Энэхүү судалгаа нь өмчийн хэлбэр, хяналт, менежментийн, хувьцаа эзэмшигчийн асуудалд чиглэгддэг. Хувьцааны төвлөрлийг тооцооны журмаар тодорхойлдог. Өмчлөл нь хувьцаа эзэмшигчийн хувьцааны хувь хэмжээгээр хэмжигддэг. Нийт 80 аж ахуйн нэгжийг судалгааны түүвэр болгон сонгон авч, хувьцааны төвлөрөл болон ашгийн удирдлагын хоорондын хамаарлыг судлахад сөрөг хамааралтай болохыг тогтоожээ.

#### Оршил

1990 оноос өмнө Монгол Улс долоон жилийн турш төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай байсан бөгөөд 1990 онд чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжсэн. Монголын хөрөнгийн бирж (МХБ) 1991 онд хувьчлал, үнэт цаасыг хөгжүүлэх зорилгоор байгуулагдсан. МХБ-ийн бүтээн байгуулалтыг үндсэндээ гурван үе шаттайгаар ангилдаг. Эхний үе шатны зорилго нь төвлөрсөн төлөвлөлтөөс зах зээлийн эдийн засагт шилжихтэй холбоотой хувьчлал байв. Энэхүү хувьчлалын үйл явц нь том, жижиг, хөдөө аж ахуйн хувьчлал гэсэн гурван хэлбэртэй байв. 90–ээд оны эхэн үед иргэд хувийн өмч, зах зээлийн эдийн засаг, улсын үйлдвэрийг худалдаж авах мөнгөтэй байх талаар ямар ч мэдлэггүй байв. Тиймээс хувьчлах зорилгоор нэг цэнхэр, гурван ягаан тасалбараас бүрдэх хөрөнгө оруулалтын тасалбар ашигласан. Цэнхэр тасалбар нь томоохон үйлдвэрүүдийг худалдаж авахад ашигладаг байсан бол ягаан тасалбаруудыг худалдаа, үйлчилгээ эрхэлдэг жижиг компаниудыг худалдаж авахад ашигладаг байв. Монгол Улсын Иргэний хуулийн дагуу бүх эрхийн бичгийг иргэдэд үнэ төлбөргүй тараасан. Иргэд томоохон үйлдвэрүүдийн хувьцааг цэнхэр тасалбараар худалдаж аваад, түүний хувьцаа эзэмшигчид болжээ. Энэхүү процессын үр дүнд хөрөнгийн зах зээл дээр 475 хувьцаат компани бүртгэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, томоохон аж ахуйн нэгжийн 25 хувийг цэнхэр эрхийн бичгээр хувьчилжээ. Ийм байдлаар улсын үйлдвэрүүдийг хувьчилж, өмчлөлийн статусаа өөрчилсөн.

#### Судалгааны шинэлэг байдал ач холбогдол

Манай улсад компаниудын хувьцааны төвлөрлийн талаар хийгдсэн судалгааны ажил харьцангуй ховор байна. Энэхүү судалгаандаа Монгол Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй I, II, III ангиллын 198 компаниудын хувьцааны төвлөрөл болон ашгийн удирдлагын хоорондын хамаарлыг судалж байгаа нь шинэлэг юм.

#### Судлагдсан байдал

“Санхүүгийн тайлангийн мэдээллийн чанар, түүнийг хэмжих нь” Г.Гантулга, 2016. Уг судалгаанд Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудаас санамсаргүй байдлаар түүвэрлэн 70 компанийн хувьцааны төвлөрлийг Жонсын шинэчлэгдсэн/Modified Jones/ загварыг ашиглан судалсан бол “Санхүүгийн тайлагналын чанар болон хувьцааны төвлөрөл хоорондын хамаарлын шинжилгээ” М.Анхзаяа 2019. Уг судалгаа нь 2013–2017 оны компаниудын санхүүгийн тайлангийн чанар, хувьцааны төвлөрөл хоорондын хамаарлыг олон хүчин зүйлийн регресс, Чанарын индекс, Beneish M-Score загваруудыг ашиглан судалсан байна. Судалгааны үр дүнд санхүүгийн тайлангийн чанар болон хувьцааны төвлөрөл хоорондоо ач холбогдолгүй гэсэн үр дүн гарсан.

#### Судалгааны арга зүй

$$TA_{i,t} = \frac{\Delta CA_{i,t} - \Delta CL_{i,t} - \Delta Cash_{i,t} + \Delta STD_{i,t} - \Delta Dep_{i,t}}{A_{i,t-1}} \quad (1)$$

$TA_{i,t}$  – Нийт аккруэль

$\Delta CA_{i,t}$  – Эрэлтийн хөрөнгийн өөрчлөлт

$\Delta CL_{i,t}$  – Богино хугацаат өр төлбөрийн өөрчлөлт

$\Delta Cash_{i,t}$  – Бэлэн мөнгөний өөрчлөлт

$\Delta STD_{i,t}$  – Дансны өрийн өөрчлөлт

$\Delta Dep_{i,t}$  – Элэгдлийн өөрчлөлт

$A_{i,t}$  – Нийт хөрөнгө

t – Жилийн индекс

i – Компанийн индекс

$$\frac{TA_{i,t}}{A_{i,t-1}} = \alpha_1 \frac{1}{A_{i,t-1}} + \alpha_2 \frac{\Delta REV_{i,t}}{A_{i,t-1}} + \alpha_3 \frac{PPE_{i,t}}{A_{i,t-1}} + \varepsilon_{i,t}$$

$TA_{i,t}$  – Нийт аккруэль

$A_{i,t}$  – Нийт хөрөнгө

$\Delta REV_{i,t}$  – Орлогын өөрчлөлт

$PPE_{i,t}$  – Цэвэр үндсэн хөрөнгө

$\varepsilon$  – алдааны утга

t – Жилийн индекс

i – Компанийн индекс

$$NDA_{i,t} = \widehat{\alpha}_1 \frac{1}{A_{i,t-1}} + \widehat{\alpha}_2 \frac{(\Delta Rev_{i,t} - \Delta Rec_{i,t})}{A_{i,t-1}} + \widehat{\alpha}_3 \frac{PPE_{i,t}}{A_{i,t-1}}$$

$NDA_{i,t}$  – Бодит аккруэль  
 $\Delta Rev_{i,t}$  – Орлогын өөрчлөлт  
 $\Delta Rec_{i,t}$  – Авлагын өөрчлөлт  
 $PPE_{i,t}$  – цэвэр үндсэн хөрөнгө  
 $\widehat{\alpha}_1$  – Альфа  
 t – Жилийн индекс  
 i – Компанийн индекс

$$DACC_{i,t} = TA_{i,t} - NDA_{i,t}$$

$DACC_{i,t}$  – Дискришн аккруэль  
 $TA_{i,t}$  – Нийт аккруэль  
 $NDA_{i,t}$  – Бодит аккруэль

$$DACC_{i,t} = \beta_0 + \beta_1(OWN) + \beta_2(SIZE) + \beta_3(LEV) + \beta_4(ROA)$$

$OWN$  – хувьцааны төвлөрөл  
 $SIZE$  – Нийт хөрөнгөөс натурал логарифм авсан  
 $LEV$  – Нийт өр төлбөрийг хөрөнгөд харьцуулсан харьцаа  
 $ROA$  – Цэвэр ашгийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа

Б) Судалгааны үр дүн

Тодорхойлогч статистикийн үр дүн. Монгол Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй I,II,III ангиллын 198 компаниудаас 5 жилийн турш тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж буй 80 компани санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг ашиглан тойм статистикийг хүснэгтээр харуулав. Санхүүгийн тайлангийн чанарыг хэмжигч Дискришн аккруэлийн дундаж нь -0.089, хамгийн их утга нь 2.374 бол хамгийн бага утга нь -2.576 байна. ROA-н дундаж нь -3297.912, хамгийн их утга нь 516.989 бол хамгийн бага утга нь -1320.600 байна. LEV дундаж нь 1.384, хамгийн их утга нь 263.905 бол хамгийн бага утга нь 0 байна. OWN буюу хувьцааны төвлөрлийн хувьд дундаж утга нь 82.6 буюу төвлөрөл өндөртэй байгааг харуулж байна. SIZE буюу нийт хөрөнгийн хувьд дундаж утга нь 15.03 төгрөг байна.

Хүснэгт. Тодорхойлогч статистикийн үр дүн

	Mean	Standard Deviation	Minimum	Maximum
<b>DACC</b>	-0.089	0.478	-2.576	2.374
<b>OWN</b>	82.6	0.195	72.1	1.000
<b>SIZE</b>	15.034	2.689	0.000	23.052
<b>LEV</b>	1.384	13.332	0.000	263.905
<b>ROA</b>	-3297.912	66027.764	-1320.600	516.989

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Корреляцийн шинжилгээний үр дүн: Дискришн аккруэль (DACC) болон хувьцааны төвлөрөл хоорондын хамаарлыг хүснэгтэд харуулав. SIZE болон DACC хоёрын хоорондын хамаарал -0.10723 сөрөг хамааралтай, OWN болон DACC хоёрын хоорондын хамаарал -0.03343 буюу сөрөг хамааралтай байна. Бусад үзүүлэлтийн хувьд ач холбогдлын түвшин багатай байна.

Хүснэгт. Корреляцийн шинжилгээний үр дүн

	DACC	OWN	SIZE	LEV	ROA
<b>DACC</b>	1				
<b>OWN</b>	-0.03343	1			
<b>SIZE</b>	-0.10723	0.148041	1		
<b>LEV</b>	-0.09654	-0.06823	-0.31942	1	
<b>ROA</b>	0.112882	0.000408	0.280303	0.48701	1

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Регрессийн шинжилгээний үр дүн. Судалгаанд авч үзсэн 80 компани санхүүгийн тайлангийн чанар болон хувьцааны төвлөрөл хоорондын хамаарал байхгүй гэсэн үр дүнд хүрлээ. Хувьцааны төвлөрөл нэг нэгжээр өсөхөд санхүүгийн тайлангийн чанар 0.123 хувиар өснө.

Хүснэгт.Регрессийн шинжилгээний үр дүн

## SUMMARY OUTPUT

Regression Statistics	
Multiple R	0.191795
R Square	0.036785
Adjusted R Square	0.027031
Standard Error	0.471549
Observations	400

## ANOVA

	df	SS	MS	F	Significance F
Regression	4	3.354305	0.838576	3.771281	0.005041
Residual	395	87.83161	0.222358		
Total	399	91.18591			

	Coefficients	Standard Error	t Stat	P-value	Lower 95%	Upper 95%	Lower 95.0%	Upper 95.0%
Intercept	0.239386	0.183	1.308123	0.191592	-0.12039	0.599162	-0.12039	0.599162
OWN	0.03102	0.13345	0.232444	0.816314	-0.23134	0.29338	-0.23134	0.29338
SIZE	-0.02397	0.009527	-2.51567	0.012276	-0.0427	-0.00524	-0.0427	-0.00524
LEV	0.013852	0.012517	1.106598	0.269141	-0.01076	0.038461	-0.01076	0.038461
ROA	3.85E-06	2.5E-06	1.542545	0.123742	-1.1E-06	8.76E-06	-1.1E-06	8.76E-06

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

## Судалгааны үр дүн, санал зөвлөмж

Судалгааны үр дүнд санхүүгийн тайлангийн чанар болон хувьцааны төвлөрөл хоорондоо ач холбогдолгүй гэсэн үр дүн гарсан.

Бидний хийсэн судалгаа нь дараах зүйлсээр хязгаарлагдаж байна.

- 2013–2018 оны хооронд тасралтгүй үйл ажиллагаа явуулсан компанийг сонгон авсан.
- 2013 оноос өмнөх онуудын санхүүгийн тайлангийн мэдээлэл дутмаг байсан.
- Санхүүгийн тайлангийн мэдээллийг ашигласан байна.
- Санхүүгийн тайлангийн чанар болон хувьцааны төвлөрөл хоорондын ач холбогдлыг судалсан.

## Цаашид

- Хөрөнгийн биржид бүртгэлтэй I ангиллын 14, II ангиллын 44, III ангиллын 140 компанийг тус бүрд нь дүн шинжилгээ хийж тооцоолох.
- Мөн хөрөнгийн биржид бүртгэлтэй бүх компаниудыг эдийн засгийн нөлөө бүхий салбараар нь ангилж тооцох.

## Ашигласан ном зүй

1. А.Наранцэцэг (2017) “The relationship between ownership structure and earnings management”
2. Г.Гантулга, 2016 “Санхүүгийн тайлангийн мэдээллийн чанар, түүнийг хэмжих нь”
3. М.Анхзаяа 2019 “Санхүүгийн тайлагналын чанар болон хувьцааны төвлөрөл хоорондын хамаарлын шинжилгээ”
4. www.schcd.mn (Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв)
5. www.mse.mn (Хөрөнгийн бирж)

## ТАНИЛЦУУЛГА

## АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК



## Asian Development Bank

буйруулах зорилготой ажилладаг. АХБ нь дэд бүтэц, нийгмийн салбарын төслүүдэд зээл, хөрөнгө оруулалт, буцалтгүй тусламж, техникийн туслалцаа үзүүлэх зэргээр санхүүжүүлж, бүс нутгийн хамтын ажиллагаагаар өөрийн гишүүн орнуудын хөгжилд дэмжин тусалсаар иржээ.

АХБ нь 1966 онд байгуулагдсан бөгөөд Филиппин Улсын Манила хотод төвтэй. Анх үүсгэн байгуулагдахад 31 гишүүнтэй байсан бол өнөөгийн байдлаар 68 гишүүн оронтой болсноос 49 нь тухайн бүс нутагт оршиж байна. Монгол Улс 1991 онд АХБ-ны гишүүнээр элсэн орсон бөгөөд Монгол Улсын санхүүгийн болон бусад салбарт дэмжлэг туслалцаа үзүүлж, хамтран ажиллаж ирсэн.

Санхүүгийн зохицуулах хорооноос АХБ-тай хамтран бичил санхүүгийн салбарт хэд хэдэн төсөл хэрэгжүүлж байгаа бөгөөд 2016 оноос эхлэн хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-ны салбарыг хөгжүүлэх төслийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Үүнд:

1. ХЗХ-ны хадгаламжийн даатгал болон тогтворжилтын санг үүсгэн байгуулах, удирдах замын зургийг гаргах;
2. ХЗХ-ны хадгаламжийн даатгал болон тогтворжилтын санг үүсгэн байгуулах ажлыг дэмжих;
3. ХЗХ-ны эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх зэрэг ажлууд багтсан.

Төслийн эхний шат буюу 2016–2018 онд тогтворжилтын сангийн хэмжээ, санг бүрдүүлэх хугацаа, хувь хэмжээ, хадгаламжийн даатгалын эхлэлтийн хөрөнгийн тооцоо, хувь хэмжээг тооцон гаргаж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх ажлын бэлтгэл болгож ХЗХ-ны санхүүгийн мэдээлэлд үндэслэн зайнаас шинжилгээ хийх, эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийн түвшингээр зэрэглэл тогтоох аргачлалын төслийг бэлтгэж туршсан. Мөн 290 ХЗХ-г хамарсан чадавхжуулах, ХЗХ-дын тогтвортой хөгжлийг хангах, эрсдэлээс хамгаалах тогтолцоог бүрдүүлэх талаарх олон улсын сайн туршлагыг хуваалцах сургалтыг 2017 оны 5–10 дугаар сард орон даяар бүсчилсэн байдлаар 9 удаа зохион байгуулж, ХЗХ-дын хөгжлийн чуулганыг 2017 оны 10 дугаар сард зохион байгуулж салбарын хөгжлийг дэмжих бодлогын талаар хэлэлцсэн.

Төслийн 2 дугаар шат 2019–2020 онд хэрэгжиж байгаа бөгөөд ХЗХ-оос гадна ББСБ-ын салбарын хөгжилд дэмжлэг үзүүлэхээр өргөтгөсөн.

ХЗХ-дын “дээвэр байгууллага” болох Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоог чадавхжуулахаар орон нутгаас 14, Улаанбаатар хотоос 12 оролцогчийг хамруулсан “Хадгаламж, зээлийн хоршооны эрсдэлийн удирдлага” сэдэвт сургалтыг 2019 оны 5 дугаар сард зохион байгуулж анхан шатны сургагч багш нарыг бэлтгэсэн.

ХЗХ-дын хяналтын зөвлөлийг чадавхжуулах, дотоод хяналтыг сайжруулах семинарыг 2019 оны 5 дугаар сард говийн бүсийн 15

ХЗХ-ны хяналтын зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захирал, нягтлан бодогч 45 оролцогч, 9 дүгээр сард хангайн бүс болон Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг 27 ХЗХ-ны 76 оролцогч, 2020 оны 01 дүгээр сард Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг 27 ХЗХ-ны хяналтын зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захирал, нягтлан бодогч 76 оролцогч буюу 69 ХЗХ-ны 197 оролцогчийг хамруулсан бөгөөд сургагч багш нарыг семинарт хамт оролцуулсан. Семинарыг 2020 оны 3–10 дугаар сард орон нутгаар бүсчлэн зохион байгуулахаар төлөвлөсөн боловч дэлхий нийтээр ковид-19 халдвар дэгдэж Монгол Улс гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг тогтоосон учраас тодорхойгүй хугацаагаар хойшуулаад байна.

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх чиглэлийн хүрээнд эрсдэлийг үнэлэх аргачлалын дагуу ХЗХ-дын 2017, 2018 оны санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланд суурилан эрсдэлийг үнэлж, зайнаас хийсэн эрсдэлийн үнэлгээ бодит байдалтай нийцэж байгаа эсэхийг 2019 онд 35 ХЗХ-нд газар дээрх шалгалтаар туршсан. Туршилтын ажлаас гарсан үр дүнгээр аргачлалд тодорхой өөрчлөлтүүдийг төслийн зөвлөхүүдтэй хамтран хийж, улмаар нийт хоршоодын 2019 оны санхүүгийн тайланд эрсдэлийн үнэлгээг хийж, үнэлгээнд тулгуурлан эрсдэл өндөртэй ХЗХ-дод авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж байна.

ХЗХ-ны салбарын 2, 3 дугаар шатны хамгаалалтын тогтолцоо буюу тогтворжилтын сан, хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэхэд хууль тогтоомжид өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай бөгөөд холбогдох өөрчлөлтүүдийг тусгасан Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад төслийн зөвлөхүүдтэй хамтран ажиллаж, 2020 оны 01 дүгээр сард төслийг олон нийтэд танилцуулж, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.


Төслийн үр дүнд ХЗХ-ны салбарт эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлж, хяналтын зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх захирлуудыг эрсдэлийн удирдлагын семинарт хамруулан чадавхжуулах замаар дотоод хяналтыг сайжруулж, хууль, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлснээр салбарын санхүүгийн зах зээлд эзлэх хувийг нэмэгдүүлэхээр тооцож байна.



# САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

## МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ РАДИОТОЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ БАЙНА

Санхүүгийн зохицуулах хороо Монголын үндэсний радиотой хамтран иргэдийн санхүүгийн боловсролд зориулж “Даатгалын ач холбогдол”, “Хувьцаа 1072” болон “Санхүүгийн үйлчлүүлэгчийн эрх ашгийг хэрхэн хамгаалах вэ” сэдвээр нэвтрүүлэг бэлдэж долоо хоног тутам радио сонсогчдод хүргэж байна.



## “САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ” ЦЭС ҮҮСГЭЛЭЭ

Санхүүгийн зохицуулах хороо “Бенекрафт” ХХК-тай хамтран [www.ikon.mn](http://www.ikon.mn) цахим хуудсанд “Санхүүгийн боловсрол” цэс нээж иргэдийн санхүүгийн боловсролд зориулж “Мөнгө угаахтай тэмцэх”, “Даатгал”, “Хурдан морь унаач хүүхдийн даатгал”, “Хөрөнгийн зах зээл” сэдвээр мэдээлэл бэлтгэж олон нийтэд түгээлээ

## ИРГЭДЭД ЗОРИУЛСАН “ТАНЫ САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛД” МЭДЭЭЛЛИЙН ДЭЛГЭЦ АЖИЛЛУУЛЖ БАЙНА

Санхүүгийн зохицуулах хорооноос олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд Иргэдэд зориулсан “Таны санхүүгийн боловсролд” мэдээллийн дэлгэцийг байршуулан ажиллуулж байна. Уг дэлгэцээр Хорооны үйл ажиллагатай холбоотой мэдээлэл, зохицуулалтын салбарын талаар богино хэмжээний анимейшн, подкаст, нэвтрүүлэг зэргийг хүргэж байна.



## ХЭРЭГЛЭГЧ

### ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ

#### ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, барагдуулахаар санал дүгнэлт гаргаж, хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг

хэрэгжүүлдэг. 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар Хяналт шалгалт, зохицуулалтын газарт хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс нийт 137 өргөдөл, гомдол ирсэн байна.

Нийт өргөдлийн тоо (улирлаар)

№	Салбар	2017.1	2017.2	2017.3	2017.4	2018.1	2018.2	2018.3	2018.4	2019.1	2020.1
1	Даатгал	42	23	29	45	40	38	25	47	43	90
2	Үнэт цаас	23	12	12	20	28	29	21	30	17	26
3	ББСБ	13	9	7	13	20	11	11	14	20	20
4	ХЗХ	8	5	1	5	4	2	30	17	2	1
	<b>Нийт</b>	<b>86</b>	<b>49</b>	<b>49</b>	<b>83</b>	<b>92</b>	<b>80</b>	<b>87</b>	<b>108</b>	<b>82</b>	<b>137</b>

Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээл, хадгаламж зээлийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо буурсан бол даатгалын салбартай холбоотой өргөдлийн тоо өсөж, ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдлийн тоонд өөрчлөлт ороогүй байна.

дээр үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаас, даатгал, банк санхүүгийн байгууллагын үйлчлүүлэгч, хадгаламж, зээлийн хоршооны гишүүд болон иргэдээс Хороонд хандаж, 2020 оны 1 дүгээр улиралд ирүүлсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг дор сийрүүлэв.

#### Салбарын үзүүлэлтүүд

Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1–д тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд санхүүгийн зах зээл

#### ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

Тайлант хугацаанд нийт 137 өргөдөл, гомдол ирснээс шийдвэрлэлтийн байдал:

Хүснэгт. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тоо

Өргөдөл гомдлын шийдвэрлэлт	Өргөдлийн тоо
Шийдвэрлэж, хариуг өгөв. Үүнээс:	
Хугацаанд нь шийдвэрлэсэн	121
Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн	-
Шийдвэрлэх шатандаа байгаа. Үүнээс:	
Хуулийн хугацаанд хянагдаж буй	10
Хугацааг нь сунган хянагдаж буй	6

Өргөдлийн шийдвэрлэлтийн үйл ажиллагааны процесс, авах арга хэмжээний хүрээ харилцан адилгүй байгаагаас хамааран тухайн өргөдлийн шийдвэрлэх хугацаа өөр өөр байгаа хэдий ч нийт өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 22 хоног болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хоногоор уртассан нь дийлэнх өргөдөл, гомдлын утга, агуулгууд тухайн мэргэжлийн нарийвчилсан ур чадвар шаардсан, оролцогч талуудын хоорондын илүү төвөгтэй маргааны хэлбэртэй болсноос гадна зарим зөрчлийн шинжтэй өргөдлийн дагуу зөрчлийн хэрэг бүртгэх, прокурорын байгууллагаар хянуулах болсонтой холбоотой.

Хүснэгт. Өргөдөл шийдвэрлэх дундаж хугацаа /хоногоор/



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

**ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИ (ОУСК) БОЛОН НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГА (НҮБ)-ААС ХАМТРАН ХӨГЖҮҮЛЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ БОЛОН ЗАСАГЛАЛ (ESG)-ЫН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД**



ОУСК болон НҮБ-ын “Тогтвортой хөрөнгийн бирж санаачилга” (SSE) нь хөгжиж буй зах зээл дэх компаниудын ESG-ын нээлттэй байдал, тайлагналын шаардлагыг өндөрсгөх, ингэснээр эдгээр орнуудын хөрөнгийн биржийг дэмжих зорилготой юм. Ил тод, нээлттэй байдал нь хариуцлагатай хөрөнгө оруулагчид болон тогтвортой компаниудыг холбож өгч байдаг. Гол зорилго нь хөрөнгө оруулагчдын итгэлийг бий болгох, хөрөнгө татах, хүчтэй зах зээлийг хөгжүүлэхэд туслах явдал юм.

### **Тогтвортой хөрөнгийн бирж санаачилга нь мэдлэг болон мэдээллийн зөрүүг нөхөх зорилготой**

Бүх хөрөнгө оруулагчид компанийн стратеги, засаглал, гүйцэтгэлийн талаарх чухал мэдээллийг шаардаж байдаг. Үүнд ESG-ын үйл ажиллагааны талаарх найдвартай мэдээлэл мөн ордог. Найдвартай мэдээллийг ил тод болгох нь хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалт болон хөрвөх чадвар бүхий үр ашигтай зах зээлийг бий болгоход чухал нөлөөтэй. Мэдээллийн ил тод байдал нэмэгдсэнээр

компаниудад нөөцийг илүү сайн удирдах, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, хямд өртөгтэй капиталын хүртээмжийг нэмэгдүүлэхэд тусалдаг. Тиймээс олон хөрөнгийн бирж, үнэт цаасны зах зээлийн зохицуулагчид ESG-ын ил тод байдал, тогтвортой санхүүжилтийг сурталчлах ажилд идэвхтэй анхаарч эхлээд байна.

Гэвч хөгжиж буй зах зээлд ийм мэдээлэл хомс байдаг. Эдгээр зах зээл дэх хөрөнгийн бирж, зохицуулагч байгууллагууд нь бүртгэлтэй компаниудын ESG тайланг сайжруулах арга барилыг хэрэгжүүлэх мэдлэг эсвэл нөөц дутмаг байх талтай. Үр ашигтай зах зээлийг бий болгохын тулд тогтмол, харьцуулж болохуйц, цаг тухайд нь мэдээлэх нь тулгамдсан асуудал болж байгаа юм. Найдвартай мэдээллийн хэрэгцээ дутмаг байгаа нь эдгээр улс орнуудын зах зээлийн тэлэлт, эдийн засгийн өсөлтийг хангахад саад болж байдаг.

ОУСК ба SSE санаачилга нь хөгжиж буй зах зээл дээрх энэхүү зөрүүг нөхөх зорилготой буюу ESG-ын ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх “ОУСК-ын гаргасан ил тод нээлттэй байдлын хэрэгсэл” – эр дамжуулан тэдгээр зах зээлийн хөрөнгийн биржүүд, хөрөнгө оруулагчид, зохицуулагч байгууллагууд болон компаниудтай хамтран ажиллах юм. Энэхүү хэрэгсэл нь саяхан гарснаас хойш Казакстан, Кени, Нигер, Перу, Гүрж, Филиппин зэрэг улсуудад зах зээл зохицуулалтын удирдамж боловсруулахад ашиглагдаж байна. Хөрөнгийн зах зээл дээрх тайланг сайжруулах чиглэлээр ОУСК хичээн ажиллаж байгаа бөгөөд үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь цахим тайлангийн хэрэгслийг компаниуд тайлангаа гаргахад ашиглаж, мөн тайлан балансаас бусад буюу ESG мэдээллийг тайлагнахад ашиглах болно.

### **Хөгжиж буй зах зээл дэх хөрөнгийн бирж болон зах зээлийн зохицуулагчид нь өөрчлөлтийн агентууд байдаг**

Хөрөнгийн бирж нь хөрөнгө оруулагчид, компаниуд, зохицуулагч байгууллагуудтай ижил түвшинд харилцдаг бөгөөд мэдээллийн нээлттэй, тогтвортой байдлын чанарыг сайжруулах онцгой байр суурьтай байдаг. Зах зээлийн зохицуулагчид нь ESG шаардлагыг сурталчлах замаар компаниудын сайн засаглал, ил тод байдлыг дэмжихэд түлхэц үзүүлж байдаг. ESG-ыг ил болгох шилдэг туршлагыг бий болгосноор эдгээр гол үүрэг гүйцэтгэгчид нь зах зээлийг бэхжүүлэх, өсөлтийн боломжийг тодорхойлох, эрсдэлийг удирдах, бизнесийн үйл ажиллагааг сайжруулах, хөгжиж буй зах зээл дэх тогтвортой компаниудад илүү их хөрөнгийг татахад тусалдаг.

ESG-ын ил тод, нээлттэй байдлын илүү өндөр стандартыг шаардах нь хөгжиж буй зах зээлд хөрөнгө оруулахтай холбоотой эрсдэлийг бууруулж, компанийн засаглал сул, нийгэм, байгаль орчны асуудалтай болон төвлөрсөн өмчлөлтэй байх зэрэг эрсдэлийг бууруулах боломжтой юм. Энэ нь эргээд илүү их хөрөнгө оруулалтыг татах болно. ESG дээр илүү сайн ажилладаг компаниуд илүү сайн тайлагнах хандлагатай байдаг бөгөөд энэ мэдээлэл нь хөрөнгө оруулагчдад сайн хөрөнгө оруулалт хийсэн гэдэгт нь илүү их баталгаа өгч байдаг.

Эх сурвалж: [www.ifc.org](http://www.ifc.org)



## ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ


### 1.1 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ



Үнэт цаасны зах зээлд нийт **530** зохицуулалттай этгээд, хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байна.

Арилжаа эрхлэх <b>2</b>	Төлбөр тооцооны <b>2</b>	Төвлөрсөн хадгаламж, үнэт цаасны арилжааны төлбөрийн <b>1</b>
ХОМК <b>25</b>	Арилжаа эрхлэгчдийн холбоо <b>1</b>	Кастодиан <b>3</b>
Андерайтерийн зөвшөөрөлтэй банк <b>2</b>	Хөрөнгө итгэмжлэн удирдах <b>4</b>	ХК <b>305</b>
ҮЦК <b>54</b>	ХАА түүхий эдийн арилжаа эрхлэх <b>1</b>	ХАА түүхий эдийн брокер <b>14</b>
ҮЦЗЗ-д аудитын үйлчилгээ үзүүлэх <b>60</b>	ҮЦЗЗ-д хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх <b>23</b>	ҮЦЗЗ-д хуулийн үйлчилгээ үзүүлэх <b>33</b>

\*ҮЦК-д брокер, дилер, андерайтер болон хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагыг хамаатуулна.




#### Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар

- Нийт зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 хувиар өсөж 2.5 их наяд төгрөгт хүрсэн бол хөрвөх чадвар 1.4 пунктээр буурч 0.4 хувьд хүрлээ.
- Хөрвөх чадвар буурахад хувьцааны арилжааны хэмжээ 35.1 тэрбум төгрөгөөр буюу 4.7 дахин буурсан нь нөлөөлжээ.

#### Үнэт цаасны зах зээлийн индекс

- ТОП-20 Индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,948.6 нэгжээр буюу 18.9 хувиар буурсан.
- MSE А индекс өмнөх оны мөн үеэс 1,544.4 нэгжээр буюу 16.3 хувиар буурсан.
- MSE Б индекс өмнөх оны мөн үеэс 661.8 нэгжээр буюу 8.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна. буюу 4.5 хувиар буурсан.







ХААБ-ээр нийт 28.3 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан нь өмнөх оны мөн үеэс 4.9 тэрбум төгрөгөөр буюу 14.7 хувиар буурсан бөгөөд зөвхөн 3 төрлийн бүтээгдэхүүн арилжигджээ.



**ХАА-н биржийн MAPIX индекс**  
 ХААБ-ээс тооцон гаргадаг Монголын хөдөө аж ахуйн индекс буюу MAPIX 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар 794,438.0 нэгжид хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 291,371.5 нэгжээр буурсан байна.





1.2 ДААТГАЛЫН САЛБАР



ДААТГАЛЫН ГҮНЗГИЙРЭЛТ

2020 оны 1 дүгээр улиралд даатгалын гүнзгийрэлт 0.44 хувьд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.01 хувиар буурсан байна.




\* Давхар даатгалын зуучлагч давхардсан тоогоор орсон болно.



ДААТГАЛЫН КОМПАНИУДЫН НИЙТ ХӨРӨНГӨ

- Тайлант улиралд нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар өсөж, өмнөх улирлаас 4.3 хувиар буурч 350 тэрбум төгрөгт хүрлээ.
- Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн жилийн өсөлт бусад даатгалын төрөлтэй харьцуулахад 15.1 хувиар өсөж 286.4 тэрбум төгрөг хүрч, салбарын нийт хөрөнгийн 81.8 хувийг эзэлж байна.
- Давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.4 хувиар буурч, 54.1 тэрбум төгрөг хүрсэн нь салбарын нийт хөрөнгийн 15.5 хувийг эзэлж байна. 2020 оны 1 дүгээр улирлаас 1 давхар даатгалын компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбоотойгоор нийт хөрөнгийн өсөлт өмнөх үетэй харьцуулахад буурсан байна.
- Урт хугацааны даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар өсөж, 9.4 тэрбум төгрөгт хүрч, салбарын 2.7 хувийг эзэлж байна.

- Ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж
- Ердийн болон урт хугацааны даатгалын давхар даатгалын хураамж
- Дотоодын давхар даатгалын компанийн нийт хураамж




НИЙТ ХУРААМЖ

- Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 2020 оны 1 дүгээр улиралд нийт 40.7 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлжээ. Үүнээс: ердийн даатгалын компаниуд 40.3 тэрбум төгрөг буюу 99.1 хувь, урт хугацааны даатгалын компани 0.4 тэрбум төгрөг буюу 0.9 хувийг бүрдүүлжээ.
- Нийт 13.1 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжид зарцуулсны 0.8 тэрбум төгрөг буюу 5.9 хувийг дотоодын давхар даатгагчид төлжээ.
- 2020 оны 1 дүгээр улирлын ердийн болон урт хугацааны даатгалын нийт хураамж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.2 хувиар өсчээ.

ДААТГАЛЫН БОЛОН ДАВХАР ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР


- Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 2020 оны 1 дүгээр улиралд 15.6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нөхөн төлбөрийн зардал 24.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Үүнээс ердийн даатгалын компаниудын нөхөн төлбөр 99.1 хувийг бүрдүүлжээ.
- Тайлант хугацаанд давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийн хэмжээ 2.9 дахин өсөж 1.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.



1.3 БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА


- 2020 оны 1 дүгээр улиралд Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр 540 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулав.
- Эдгээрийн 75 буюу 13.9 хувь нь орон нутагт, 465 буюу 86.1 хувь нь нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.

Нийт банк бус санхүүгийн байгууллагуудын 5.2 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай, 94.8 хувь нь үндэсний хөрөнгө оруулалттай байна.



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХӨРӨНГӨ

2020 оны 1 дүгээр улиралд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ 1.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 381.3 тэрбум төгрөгөөр буюу 27.3 хувиар өсжээ.






**НИЙТ ЗЭЭЛ**


2020 оны 1 дүгээр улирлын байдлаар салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 30.4 хувиар буюу 296.3 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Зээлийн хүү: 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн жигнэсэн дундаж сарын хүү 3.0 хувьд хүрч буурлаа.

2020 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт зээлийн үлдэгдлийн 97.2 хувийг төгрөгөөр олгосон зээл, үлдсэн 2.8 хувийг валютаар олгосон зээл эзлэж байна.




**97.2%**



**1.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО**

**ХЗХ-ДЫН ТОО БА ГИШҮҮД**

- 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо 254-т хүрч өмнөх оны мөн үеэс 9.9 хувиар буурлаа.
- ХЗХ-дын гишүүдийн тоо 2019 оны 1 дүгээр улиралд 66,296 байсан бол тайлант улиралд 12.7 хувиар өсөж 74,701-т хүрчээ.



**АЖИЛЛАГСАД**

**810**

ХЗХ-дын нийт ажиллагсдын тоо өнгөрсөн оны мөн үеэс 3.0 хувиар нэмэгдсэн бөгөөд түүний 73.1 хувь нь эмэгтэй

**НИЙТ ГИШҮҮДИЙН**

**40,767**


ЗЭЭЛДЭГЧ

**38,066**

ХАДГАЛАМЖ  
ЭЗЭМШИГЧ


**НИЙТ ХӨРӨНГӨ, ТҮҮНИЙ ӨСӨЛТ**

- Тайлант улиралд нийт хөрөнгө өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар өсөж 229.5 тэрбум төгрөгт хүрлээ.
- Хөрөнгийн өсөлт өмнөх оны мөн үеэс 23.2 пунктээр буурчээ.



# ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

## КОВИД-19: ТӨСВИЙН ХӨГЖЛИЙН ЯВЦ, ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИНЭЧЛЭЛТ



Тахлын болон карантины үеэр эдийн засгийн өсөлтийн бууралтыг удаашруулах зорилгоор Дэлхийн улс орнуудын Засгийн газрын гуравны хоёроос дээш хувь нь 2020 оны 4 дүгээр сараас хойш төсвийн дэмжлэгээ өргөжүүлсэн байна. Эдгээр арга хэмжээ нь хүний амь насыг аврах, амьжиргааны түвшин, ажил эрхлэлт, бизнесийн харилцааг хадгалахад тусалсан. Одоо зарлагдсан төсвийн арга хэмжээг дэлхийн хэмжээнд 11 их наяд ам.доллар гэж тооцож байгаа бөгөөд 2020 оны 4 дүгээр сараас хойш төсөв 8 их наяд доллараар нэмэгдсэн байна. Тал төсөв болох 5.4 их наяд доллар нь Засгийн газрын төсөвт шууд нөлөөлдөг нэмэлт зардал юм. Үлдсэн тал нь (5.4 их наяд доллар) нь зээл, хөрөнгө оруулалт, баталгаа зэрэг төрийн өмчит банк, аж ахуйн нэгжүүдээр дамжуулан хөрвөх чадварыг дэмжих юм. Энэ нь мөнгөн гүйлгээг хадгалах, дампуурлыг хязгаарлахад туслах боловч эдгээр олон нийтийн оролцоо алдагдал хүлээх тохиолдолд Засгийн газрын өр нэмэгдэж болзошгүй. G20-ийн эдийн засаг нь дэлхийн санхүүгийн дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд одоо төсвийн арга хэмжээ ДНБ-ий 6 хувьтай байгаа бөгөөд 4-р сард ДНБ-ий ердөө 3 хувьтай байсан.

### Дэлхийн хэмжээнд Засгийн газрын өр, алдагдал

Үйлдвэрлэл огцом буурч, улмаар орлого буурах нь Засгийн газрын өр болон алдагдал нэмэгдэхэд хүргэв. Суурь хувилбарын дагуу дэлхийн нийтийн өрийн хэмжээ бүх хугацаанд хамгийн дээд хэмжээнд хүрэх төлөвтэй байгаа бөгөөд 2020–21 онд ДНБ-ий 101 хувиас давсан байх ба энэ нь жилийн өмнөхөөс 19 хувиар өссөн үзүүлэлт байх юм. Үүний зэрэгцээ төсвийн нийт алдагдал 2020 онд ДНБ-ий 14 хувьтай тэнцэх төлөвтэй байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 10 пунктээр их байна. Төсвийн хөрөнгө оруулалтаас гадна татвар, нийгмийн хамгааллаас гарах автомат тогтворжуулагчид нь (automatic stabilizers from taxes and social protection) эдийн засгийн хямралын үеэр өрхийн орлогын уналтыг зөөлрүүлэхэд туслахаас гадна алдагдлыг дунджаар гуравны нэгээр өсгөхөд нэмэр болох юм. Энэ жилийн сүүлээр аюулгүй, үр дүнтэй вакцин бэлэн болсон тохиолдолд төсвийн санхүүжилт урьдчилсан төлөвөөс багаар муудах боломжтой.

### Төсвийн хөгжлийн явц ба улс орны орлогын бүлгүүдийн төлөв байдал

Ихэнх дэвшилтэт эдийн засагтай орнууд үйл ажиллагаа нь хүлээгдэж байснаас илүү нягтаршилтай байгаа тул санхүүгийн дэмжлэгийг үе шаттайгаар хэрэгжүүлсэн. Төсвийн нийт алдагдал энэ онд дунджаар

ДНБ-ий 16 хувь болж, өнгөрсөн оныхоос 13 пунктээр өсч, Засгийн газрын өр 2020–21 оны хооронд ДНБ-ий 130 хувиас давах төлөвтэй байна. Зарим дэвшилтэт эдийн засагтай орнуудын (Франц, Герман, Итали, Япон, Их Британи) хөрвөх чадварын томоохон дэмжлэг нь ихээхэн хэмжээгээр авах, алдагдах тохиолдолд санхүүгийн эрсдэлийг бий болгодог. Өндөр хөгжилтэй орнуудын зээлийн өрийн өртөг бага хэвээр байх төлөвтэй байна. Төсвийн дэмжлэгийн хувьд АНУ 4 дүгээр сарын сүүлээр өөр нэг багц (483 тэрбум доллар буюу ДНБ-ий 2 хувь) –ийг баталж, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд нэмэлт зээл олгож байна. Япон улс 5 дугаар сарын сүүлээр 1,1 их наяд ам.долларын (ДНБ-ий 22 хувь) томоохон багц гаргасан байна. Энэ багц нь тахлын нөлөөлдөг өртсөн аж ахуйн нэгжүүдэд өргөжүүлсэн хөнгөлөлттэй зээлийг багтаасан. Герман улс 6 дугаар сард ногоон, дижитал эдийн засаг дахь үйл ажиллагааг нэмэгдүүлэх арга хэмжээ авч шинэ багц (130 тэрбум евро буюу ДНБ-ий 4 хувь, 2020–21 оны хооронд) баталлаа. Европын Холбоо 2021–27 оны хооронд 750 тэрбум евро (ДНБ-ий 6 хувь) –г санал болгов. Үүнд буцалтгүй тусламжид суурилсан нөхөн сэргээх сан орох бөгөөд ногоон байгууламжийг сэргээх, гишүүн орнуудын өрийн тогтвортой байдалд жигд бус нөлөөллийг бууруулах боломжтой болно.

Хөгжиж буй зах зээлийн эдийн засагтай орнуудад тахлын эсрэг төсвийн дундаж нь одоогоор ДНБ-ий 5 хувьтай тэнцэх хэмжээтэй боловч дэвшилтэт эдийн засагтай орнуудаас бага байна. Төсвийн алдагдал 2020 онд дунджаар ДНБ-ий 10.5 хувь болж огцом өсөх төлөвтэй байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс хоёр дахин их байна. Ингэснээр төсөв тэлж, түүхий эдийн орлого буурч, гадаад зээлийн өртгийг ихэсгэж байгаа тул дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал сүүлийн үед арай зөөлөрсөн ч хямралын өмнөх үеэс илүү хатуу хэвээр байна. Засгийн газрын өр 2020 онд ДНБ-ий дунджаар 63 хувь байх төлөвтэй байгаа бөгөөд жилийн өмнөхөөс 10 пунктээр өссөн хандлагыг үргэлжлүүлэн үзүүлж байна. Энэтхэг улс нь бизнес эрхлэгчид, үйлдвэрүүдэд зээл, баталгаа, харин санхүүгийн байгууллагууд болон цахилгаан эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалт хийх замаар хөрвөх чадварын дэмжлэгийг зарлажээ (ДНБ-ий 4%). Өмнөд Африк нь ажилгүйдлийн дэмжлэгийг богино хугацаагаар өргөжүүлж, эмзэг бүлгийн өрхүүдэд мөнгөн шилжүүлэг хийжээ. Үйл ажиллагаа сэргэж эхэлж байгаатай холбогдуулан БНХАУ нь нийгмийн аюулгүй байдлын сүлжээ, эмнэлгийн байгууламж, дижитал дэд бүтцийг өргөжүүлэх замаар эмзэг компаниуд болон өрхүүдэд анхаарлаа хандуулсаар байна.

Бага орлоготой хөгжиж буй улс орнууд санхүүжилтийн хатуу бэрхшээлтэй байнга тулгардаг тул тахлын дараах нөлөөлөл бага байгаа бөгөөд тахлын эсрэг төсвийн хариу арга хэмжээ цомхон байв. Жишээлбэл, Нигери улс нь ажилчдыг хадгалж үлдэхийн тулд ажил олгогчдод татварын хөнгөлөлт үзүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлыг нэмэгдүүлсэн (ДНБ-ий 0.3 хувь) бол, харин Этиоп улс хоол хүнс, орон байраар хангах үйлчилгээг (ДНБ-ий 1.8 хувь) өргөжүүлжээ. Вьетнам дахь дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд ядуу иргэдэд бэлэн мөнгө шилжүүлэх, одоо байгаа нийгмийн хамгааллын хөтөлбөрт хамрагдах тэтгэмжийн хэмжээг өсгөх зэрэг

ажлууд орсон байна (ДНБ-ий 1.2 хувь). Үүний үр дүнд орлого багатай хөгжиж буй орнуудын алдагдал 2020 онд ДНБ-ий 6 хувьд хүрч, энэ

нь өнгөрсөн оныхоос 2 пунктээр өссөн бол, газрын тос экспортлогч орнуудын хувьд алдагдал нэлээд өндөр байх төлөвтэй байна.

Хүснэгт. Засгийн газрын нэгдсэн төсвийн баланс ба нийт өр, 2018–21

	Төсвийн нийт баланс				Нийт өр			
	2018	2019	2020	2021	2018	2019	2020	2021
<b>Дэлхий</b>	<b>-3.1</b>	<b>-3.9</b>	<b>-13.9</b>	<b>-8.2</b>	<b>81.2</b>	<b>82.8</b>	<b>101.5</b>	<b>103.2</b>
<b>G20</b>	<b>-3.7</b>	<b>-4.5</b>	<b>-15.4</b>	<b>-9.1</b>	<b>88.6</b>	<b>90.4</b>	<b>111.2</b>	<b>113.3</b>
<b>Дэвшилтэт эдийн засаг</b>	<b>-2.7</b>	<b>-3.3</b>	<b>-16.6</b>	<b>-8.3</b>	<b>104.0</b>	<b>105.2</b>	<b>131.2</b>	<b>132.3</b>
Дэвшилтэт G20	-3.3	-4.0	-18.0	-9.1	111.6	113.2	141.4	142.9
АНУ	-5.8	6.3	-23.8	-12.4	106.9	108.7	141.4	146.1
Евро бүс	-0.5	-0.6	-11.7	-5.3	85.8	84.1	105.1	103.0
Герман Улс	1.9	1.5	-10.7	-3.1	61.9	59.8	77.2	75.0
Франц Улс	-2.3	-3.0	-13.6	-7.1	98.1	98.1	125.7	123.8
Итали Улс	-2.2	-1.6	-12.7	-7.0	134.8	134.8	166.1	161.9
Испани Улс	-2.5	2.8	-13.9	-8.3	97.6	95.5	123.8	124.1
Япон Улс	-2.5	-3.3	-14.7	-6.1	236.6	238.0	268.0	265.4
Английн Нэгдсэн Вант Улс	-2.2	-2.1	-12.7	-6.7	85.7	85.4	101.6	100.5
Канад Улс	-0.4	-0.3	-12.6	-5.8	89.7	88.6	109.3	108.8
Австрали Улс	-1.2	-3.9	-8.6	-8.4	41.5	45.0	56.8	64.3
БНСУ	2.6	0.4	-3.6	-2.4	40.0	41.9	49.5	53.4
<b>Хөгжиж буй зах зээлийн эдийн засаг</b>	<b>-3.8</b>	<b>-4.9</b>	<b>-10.6</b>	<b>-8.5</b>	<b>48.9</b>	<b>52.4</b>	<b>63.1</b>	<b>66.7</b>
Ойрх Дорнод, Хойд Африк, Афганистан, Пакистан улсуудын газрын тос үйлдвэрлэгчдийг эс тооцвол	-4.0	-5.0	-10.6	-8.5	50.4	53.9	64.4	68.1
Хөгжиж буй G20	-4.3	-5.4	-11.3	-9.1	49.4	53.0	54.1	68.3
Ази	-4.5	-6.0	-11.4	-9.8	49.3	53.5	64.9	70.3
БНХАУ	-4.7	-6.3	-12.1	-10.7	47.0	52.0	64.1	70.7
Энэтхэг Улс	-6.3	-7.9	-12.1	-9.4	69.6	72.2	84.0	85.7
Индонез Улс	-1.8	-2.2	-6.3	-5.0	30.1	30.5	37.7	40.3
Европ	0.4	-0.6	-6.9	-4.8	29.3	29.0	36.4	37.1
ОХУ	2.9	1.9	-5.5	-3.9	13.5	13.9	18.5	18.8
Турк Улс	-3.7	-5.3	-8.4	-7.5	30.4	33.0	40.6	42.2
Латин Америк	-5.2	-4.0	-10.3	-4.8	66.6	70.6	81.5	79.7
Бразил Улс	-7.2	-6.0	-16.0	-5.9	87.1	89.5	102.3	100.6
Мексик Улс	-2.2	-2.3	-6.0	-4.0	53.6	53.7	65.9	66.3
Ойрх Дорнод, Хойд Африк, Афганистан, Пакистан улсууд	-2.9	-3.9	-9.8	-7.8	40.1	44.7	55.2	56.4
Саудын Араб	-5.9	-4.5	-11.4	-5.6	19.0	22.8	35.2	36.8
Хойд Африк	-4.1	-6.3	-14.8	-11.0	56.7	62.2	79.9	84.6
<b>Бага орлоготой хөгжиж буй орнууд</b>	<b>-3.8</b>	<b>-4.1</b>	<b>-6.1</b>	<b>-5.1</b>	<b>42.9</b>	<b>43.1</b>	<b>48.2</b>	<b>49.0</b>
Нигери Улс	-4.3	-5.0	-7.3	-5.7	27.7	29.1	36.5	36.8
<b>Газрын тос үйлдвэрлэгчид</b>	<b>-0.6</b>	<b>-1.0</b>	<b>-8.4</b>	<b>-5.5</b>	<b>42.7</b>	<b>45.1</b>	<b>56.1</b>	<b>56.6</b>


Эх сурвалж: Олон улсын валютын сан

# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2020 оны 7 дугаар сарын 24-ны өдөр

S&P 500 /^GSPC/


**3,235.66** -40.36 (-1.23%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

Nikkei 225 /^N225/


**22,751.69** -132.59 (-0.58%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

FTSE 100 /^FTSE/

**6,138.10** -70.23 (-1.14%)



Эх сурвалж: [www.finance.yahoo.com](http://www.finance.yahoo.com)

Dubai Financial Market General Index DFMGI:IND

**2,052.65** -12.65 /-0.61%/



Эх сурвалж: [www.Bloomberg.com](http://www.Bloomberg.com)

Centre	GFCI 27		GFCI 26		Change in	
	Rank	Rating	Rank	Rating	Rank	Rating
New York	1	769	1	790	0	▼21
London	2	742	2	773	0	▼31
Tokyo	3	741	6	757	▲3	▼16
Shanghai	4	740	5	761	▲1	▼21
Singapore	5	738	4	762	▼1	▼24
Hong Kong	6	737	3	771	▼3	▼34
Beijing	7	734	7	748	0	▼14
San Francisco	8	732	12	736	▲4	▼4
Geneva	9	729	26	706	▲17	▲23
Los Angeles	10	723	13	735	▲3	▼12
Shenzhen	11	722	9	739	▼2	▼17
Dubai	12	721	8	740	▼4	▼19
Frankfurt	13	720	15	733	▲2	▼13
Zurich	14	719	14	734	0	▼15
Paris	15	718	17	728	▲2	▼10
Chicago	16	717	16	732	0	▼15
Edinburgh	17	716	29	701	▲12	▲15
Luxembourg	18	715	25	708	▲7	▲7
Guangzhou	19	714	23	711	▲4	▲3
Sydney	20	713	10	738	▼10	▼25

Эх сурвалж: www.globalfinancialcentres.net



📍 Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, Монгол Улс 15160

☎ +976-51-264444

✉ press@frc.mn

🌐 www.frc.mn

📘 Санхүүгийн зохицуулах хороо

🐦 @FRC\_of\_Mongolia